



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ХЭРЭГСЭЛ БА ШҮҮГЧИЙН
ХАРААТ БУС, ШҮҮХИЙН БИЕ
ДААСАН БАЙДАЛ**

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2022.11.09

ТОВЬЁГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ОНОЛЫН ОЙЛГОЛТ	5
1.1 Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын тухай онолын ойлголт	5
1.2 Чөлөөт хэвлэл мэдээллийн тухай ойлголт	8
1.3 Шүүхээс хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцаа болон шүүхийн хараат бус байдал.....	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС, ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ	14
2.1 Монгол Улсын Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, хүлээлгэх хариуцлага.....	14
2.2 Шүүхийн Ерөнхий зөвлөлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйлдэлтэй холбоотойгоор ирүүлсэн нөлөөллийн мэдүүлэг болон түүнийг шийдвэрлэсэн байдал.....	16
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА: СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙД ХОЛБОГДОХ ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО.....	18
3.1 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	18
3.2 Холбооны Бүгд Найрамдах Герман улс.....	22
ДҮГНЭЛТ, САНАЛ	28
НОМ ЗҮЙ	30

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЕШЗЗ	Европын Шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл
ИБУИНВУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
МҮОНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУСХ	Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БА ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС, ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ

Энэхүү судалгааг Монгол Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдан, Иргэний эрх зүйн секторын судлаачид А.Нэмүүлэн, Б.Номинсогоо, П.Эрхэмбаяр, О.Төрболд, С.Юмжирдулам нар хийж гүйцэтгэлээ.

Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал болон хэвлэл мэдээллийн тухай онолын ойлголт, Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, хүлээлгэх хариуцлага, Сэтгүүлчийн ёс зүйн дүрэмд шүүх, шүүгчид нөлөөлөх болон шүүх эрх мэдэлтэй холбоотой хүлээх хариуцлагын зохицуулалтын харьцуулсан судалгаа гэсэн үндсэн асуудлын хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны хамрах хүрээ

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын талаарх судалгааг хийж гүйцэтгэхдээ ХБНГУ болон ИБУИНВУ-ын эрх зүйн зохицуулалт болон сэтгүүлчийн ёс зүйн дүрмийн зохицуулалт, Монгол Улс дахь 2020-2023 оны эхний хагас жил хүртэлх хэвлэл мэдээллийн байгууллагад хамаарах нөлөөллийн мэдүүлгийн тоон мэдээлэлд суурилан уг ойлголтыг онолын болон практикийн үүднээс хэрхэн авч үзэж буй талаар судаллаа.

Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ системчлэх, анализ хийх, харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашигласан.

Судалгааны бүтэц

Энэхүү судалгаа нь онолын ойлголт, хэвлэл мэдээллийн байгууллагаас шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд нөлөөлөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт болон нөлөөллийн талаарх дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа, дүгнэлт, санал, ном зүй гэсэн хэсгээс бүрдэнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОНОЛЫН ОЙЛГОЛТ

1.1 Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын тухай онолын ойлголт

Эрх зүйт төрийн үндэс нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал бөгөөд төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл санааны дагуу бий болсон бие даасан, хараат бус шүүх эрх мэдэл нь эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болдог.

Шүүх эрх мэдэл нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болохын хувьд дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр тус бүрэн эрхийг эдэлдэг. Иймээс шүүх эрх мэдэл бие даасан, хараат бус байх зарчим, түүнийг хангах баталгааг ихэнх улс орнууд Үндсэн хуульдаа тунхаглаж, Шүүхийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулсан байдаг.

Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх)-ын Дээд шүүхийн шүүгч Дэвид Сүүтэр (David Souder) “Үндсэн хуульд шүүх эрх мэдэл хэрхэн туссаныг иргэд олон нийт ойлгож, ухамсарлаагүй цагт шүүхийн хараат бус байдалд аюул учирдаг”¹ гэж дурдсан байна. НҮБ-ийн “Шүүхийн хараат бус байдлын тухай үндсэн зарчмууд” хэмээх баримт бичгийн “Шүүхийн бие даасан байдал” гэсэн хэсгийн 2 дугаар зүйлд “Шүүх аливаа хэрэг, маргааныг ямар ч нөхцөлд эсхүл ямар ч шалтгаанаар, шууд болон шууд бусаар аливаа нэгэн хөндлөнгийн хязгаарлалт, зүй бус нөлөөлөл, албадлага, дарамт-барьцаа, заналхийлэл эсхүл оролцоогүйгээр нотлох баримтад үндэслэн хуульд нийцүүлэн шийдвэрлэх ёстой” хэмээн тодорхойлсон байдаг.²

Монгол Улсын Үндсэн хуулийн (цаашид “Үндсэн хууль” гэх) дөчин есдүгээр зүйлд шүүх хүний эрхийн жинхэнэ баталгаа байхын тулд шүүгчид нь бусдаас хараат бусаар бие даан шийдвэр гаргах, ажиллах зарчимтайг тунхаглаж, улмаар энэ нь шүүхийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааг тогтооход баримтлах үндсэн зарчим байхыг тодорхойлсон бөгөөд дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж тус тус заасан. Энэ нь шүүх бие даасан байх, шүүгч хараат бус байх, шүүгч зөвхөн хуульд захирагдах гэсэн харилцан хамааралтай хос зарчмууд юм.³

Шүүгчийн хараат бус байдал нь албан үйл ажиллагааны болон хувийн гэсэн хоёр талтай бөгөөд хувийн хараат бус байдал нь дотроо албаны болон мэргэжлийн гэсэн хоёр талтай байдаг байна.⁴ “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг

¹ David Souder (Supreme Court Justices) Library Bining-Septemder, 1992

² Basic Principles on the Independence of the Judiciary, <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-independence-judiciary> (Сүүлд үзсэн 2023.10.24)

³ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, 2 дугаар дэвтэр, 2004, 132 дахь тал.

⁴ Ч.Өнөрбаяр “Шүүгчийн хараат бус байх зарчим түүний онолын үндэслэл, шалгуур” *Эрх зүйт ёс*, 2010, 143 дахь тал.

бэхжүүлэх нь” бодлогын судалгааны хүрээнд НҮБ-ын “Шүүхийн хараат бус байдлын суурь зарчмууд”, Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмууд, Шүүхийн хараат бус байдлын Бээжингийн тунхаг зэрэг олон улсын баримт бичиг, шүүхийн хараат бус байдлын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд тулгуурлан Шүүхийн хараат бус байдлын дархлааны институцүүдэд дараах 11 зүйлийг багтаасан байна.

1. Шүүх эрх мэдлийн суурь хараат бус байдал;
2. Шүүхийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх баталгаа;
3. Улс төрийн болон бусад нөлөөллөөс хамгаалагдсан баталгаа;
4. Шүүхийн эдийн засгийн баталгаа;
5. Шүүхийн бие даасан захиргаа;
6. Шүүгчийн хараат бус байдлын захиргаа;
7. Шүүгчдийн байгууллага;
8. Шүүгчид бүрэн эрх олгох арга;
9. Шүүх доторх хараат бус байдал;
10. Шүүгчдийн сахилга, хариуцлага, ёс зүй, хувийн хараат бус байдал;
11. Шүүгчдийн хариуцлага шүүн таслах ажиллагааны үр нөлөө.

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” хэмээн хуульчилсан. Үндсэн хуулийн энэ заалтын “иргэн хэн боловч” гэдэгт Үндсэн хуулийг дагаж мөрдөх үүрэг бүхий хэн бүхэн хамаарах бөгөөд шүүгч шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон. Энэ хүрээнд шүүгчийн хараат бус байдлыг хангахад чиглэсэн нэг оролдлого нь шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөх болсон явдал юм.

Монгол Улсын Шүүхийн тухай /2021 он/ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “*нөлөөллийн мэдүүлэг*” гэж шүүгч шүүх бүрэлдэхүүнд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг хэлнэ” гэж тусгасан. Мөн хуулийн 5 дугаар зүйлд “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал”-ийн талаарх Үндсэн хуульд тусгасан эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан бол 45 дугаар зүйлд нөлөөллийн мэдүүлгийг хэрхэн хөтлөх талаар тусгаж, 45 дугаар зүйлийн 45.2 дах хэсэгт “Энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загвар хөтлөх, шийдвэрлэх журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж тус тус хуульчилсан байна.

Улмаар Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам”-ыг баталсан. Уг журмаар нөлөөллийн мэдүүлгийн загвар, түүнийг хөтлөх, бүртгэх, шийдвэрлэх процессыг зохицуулсан бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөл мэдүүлэгт тусгагдан үйлдлийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан

шийдвэрлүүлж, шийдвэр албажсаны дараа холбогдох мэдээллийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулан нийтэд түгээхээр зохицуулжээ.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүхийн иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн этгээдэд дараах хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулахаар зохицуулсан. Үүнд:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус байдалд халдсан, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулсан хэн боловч хуулийн хариуцлага хүлээнэ” хэмээн мөн хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж, 117.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”⁵ гэж;
2. Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”⁶ гэж;
3. Зөрчлийн тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгчийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл шүүх шүүгчийн аюулгүй байдлын журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”⁷ гэж тус тус зохицуулжээ.

Түүнчлэн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 331 дүгээр тогтоолын хавсралтаар “Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам”⁸-ыг баталсан бөгөөд уг журамд нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх ажиллагаа хамаарахгүй байхаар харин “шүүгчээс Шүүхийн Ерөнхий зөвлөлд хандан шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээгээр шүүгчийн ажил хэргийн нэр хүндтэй холбоотой

⁵ Монгол Улсын Шүүхийн тухай хууль, (2021), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021>

⁶ Эрүүгийн хууль, (2015), <https://legalinfo.mn/mn/detail/11634>

⁷ Зөрчлийн тухай хууль, (2017), <https://legalinfo.mn/mn/detail/12695>

⁸ Шүүхийн Ерөнхий зөвлөл, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдийн 331 дугаар тогтоол, “Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам”, https://judcouncil.mn/site/decision_full/143

гарсан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг харилцааг зохицуулна” гэж тусгасан байна. Уг журмаар зөвхөн тухайлсан хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад шүүгчид нөлөөлөх гэж оролдсон тохиолдлоос бусад үед шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх оролдлого гарсан тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгасан байна.

1.2 Чөлөөт хэвлэл мэдээллийн тухай ойлголт

Чөлөөт хэвлэл мэдээллийн тухай ойлголт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэн нь “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх”, “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах” эрхтэй салшгүй холбоотой юм. Мөн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /1998 он/ хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино” гэж заасан байна.

Хэдийгээр Монгол Улсын иргэн нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг баталгаатай эдлэх боловч Үндсэн хуулийн арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх ёстой.

Иймээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ эдлэхдээ Иргэний хуулийн /2002 он/ 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт заасны дагуу бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тараасан бол түүнийгээ нотлох, хэрвээ нотолж чадаагүй бол тухайн мэдээллээ няцаах үүргийг хүлээнэ. Харин Эрүүгийн хуулийн /2015 он/ 13.14 дүгээр зүйлд зааснаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тус тус зохицуулж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх хэвлэн нийтлэх эрх чөлөө эдлэхдээ бусдыг гутаасан болон илт худал мэдээлэл тараахгүй байх агуулгаар хязгаарлалт тогтоосон байна.

Харин хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухайд хэвлэл мэдээллийн шинэ орчин дахь хариу өгөх эрхийн талаарх 2004 оны 16 тоот зөвлөмжид “хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг нь олон нийтэд редакц хийсэн мэдээлэл тогтмол түгээх харилцаа холбооны аливаа хэрэгслийг хэлэх бөгөөд энэ нь онлайн эсвэл офлайн байх эсэх нь ач холбогдолгүй тул сонин, сэтгүүл, радио, телевиз, вебэд суурилсан мэдээний үйлчилгээ зэргийг хамааруулж үзнэ.” хэмээн тодорхойлсон байна.⁹

⁹ Adopted by the Committee of Ministers on 15 December 2004., Нээлттэй нийгэм форум, Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд өгөх санал, (дам ишлэв), https://www.law-democracy.org/wp-content/uploads/2010/07/10.04.Mongolia.Press-Law-Analysis.Mong_.pdf (Сүүлд үзсэн 2023.11.07)

“Аливаа мэдээлэл нь мэдээллийн харилцаанд оролцогч субъектын тодорхой үйлдэл, үйл ажиллагаагаар дамжиж олон нийтэд хүрч, нийгмийн оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж байдаг. Энэ үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна”¹⁰ гэж үзсэн байна. Дээрх үе шатад мэдээлэл хайх, мэдээлэл олж авах, мэдээлэл тараах, түгээх хамаарахаар ангилсан бол Нийтийн ил тод мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д тус тус зааснаар “мэдээлэл ашиглах”, “мэдээлэл боловсруулах” “мэдээлэл цуглуулах” гэж ангилжээ.

Мөн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд төрөөс хяналт тавихгүй байхыг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийтэлж, нэвтрүүлж буй зүйлийнхээ хариуцлагыг хүлээхээр хуульчилсан бол Нийтийн ил тод мэдээллийн тухай /2021 он/ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилна” гэж заажээ. Уг хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэл гэж “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг”, хязгаарлалттай мэдээлэл гэж “Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг”, хаалттай мэдээлэл гэж “Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг” хэмээн тус тус зохицуулсан байна.

Монгол Улсын Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороод 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг баталсан байна. Уг зарчимд “*үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно*” гэж нэгдүгээр бүлгээрээ сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эрхэмлэх үнэт зүйл, баримтлах үндсэн зарчмаа тунхагласан байна. Мэргэжлийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, мэргэжлийн байгууллагууд ёс зүйтэй сэтгүүл зүйг хөгжүүлэн, иргэд олон нийтэд үнэн зөв мэдээлэл түгээх нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буй хэрэг болно.

1.3 Шүүхээс хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцаа болон шүүхийн хараат бус байдал

Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх гаднын нөлөөлөл нь олон хэлбэртэй байдаг. Тухайлбал, төрийн байгууллагын албан тушаалтнууд эсхүл хэрэг маргааны оролцогч талуудын зүгээс тодорхой хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар шүүгчдэд тушаал заавар өгөх зэргээр шууд нөлөөлөх нь ч бий. Түүнчлэн нөлөөллийн шууд бус хэлбэрүүд ч байна. Үүний нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм. Тийм ч учраас шүүхээс хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааны талаар дэлгэрүүлэн авч үзэх шаардлагатай.

¹⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой судалгааны тайлан, 2004.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг хангаад зогсохгүй Хүний эрхийн Европын шүүхийн тэмдэглэсэнчлэн “ардчиллын манаач”-ийн үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ зарим тохиолдолд хувь хүний нэр хүндэд халдах, гэм буруугүйд тооцох зарчмыг алдагдуулах зэргээр хүний хувийн нууцын халдашгүй байдлыг зөрчих явдал гардаг. Мөн Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжийн 46-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ил тод, нээлттэй явуулах гэдэг нь шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах, иргэдийг ажиглагчаар оролцох боломжоор хангах ёстой гэсэн үг боловч сүүлийн үеийн аудио, дүрс бичлэгийн төхөөрөмж нь хэргийн үйл баримт, шүүх хуралдааны талаар хэт дэлгэрэнгүй үзүүлснээр зарим нэг сөрөг үр дагаврыг бий болгодог. Тодруулбал, шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах нь нэг талаараа шүүх хуралдаан хэрхэн явагддаг болон шүүхийн тогтолцооны талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх давуу талтай ч нөгөө талаар шүүх хуралдааны танхимд камер байрлуулсан нь оролцогчдын (шүүгч, прокурор, өмгөөлөгч, нэхэмжлэгч, хариуцагч, гэрч гэх мэт) зан байдлыг өөрчлөх сөрөг үр дагавартай”¹¹ хэмээн заасан байна.

Эрүүгийн хэргийн хувьд шүүхээс гэм бурууг эцсийн байдлаар тогтоогоогүй байхад хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүгдэгчийг гэм буруутай мэт ташаа мэдээлэл түгээдэг. Гэвч хэрвээ шүүхээс шүүгдэгчийг цагаатгах тухай шийдвэр гаргасан тохиолдолд түүний нэр хүндэд ноцтой гэм хор нэгэнт учирсан байх бөгөөд шүүхийн тогтоол, шийдвэрээр түүнийг залруулах боломжгүй байдаг.¹² Өөрөөр хэлбэл гэмт хэргийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээтэй мэдээлэх нь хэрэг хянан шийдвэрлэх явцад прокурор, шүүгдэгч, өмгөөлөгч нарт хүндрэл учруулдаг.¹³

Жишээлбэл, Тулузын эдийн засгийн сургуулийн ахисан түвшний судалгааны хүрээлэнгийн доктор Арнауд Филипп болон Чикагийн Их сургуулийн доктор Ауреллээ Оусс нар нь 2016 онд Франц улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт хэвлэл мэдээлэл хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгааны явцад шүүх хурлын өмнөх орой болон дараах орой цацагдсан мэдээний үр нөлөөг судлахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь цагаатгахад нөлөөлдөггүй харин ял оногдуулахад нөлөөлдөг гэсэн дүгнэлт гарсан байна. Тодруулбал өмнөх өдөр нь гэмт хэргийн талаар мэдээллүүд цацагдахад оногдуулах ялын хэмжээ хүнд буюу дунджаар 83 хоногоор илүү байна¹⁴ гэж үзсэн байна. Мөн гэмт хэргийн нөхцөл байдлыг сурвалжилсны нэгэн адил хууль хэрэглээ, шүүн таслах ажиллагааны талаар мэдээлсний маргааш оногдуулсан ял нь ийм мэдээлэл байхгүй үед оногдуулсан ялын дунджаас 37 хоногоор доогуур байгаа нь

¹¹ Opinion no. 7 (2005) of the Consultative Council of European judges (ccje) to the attention of the committee of ministers of the Council of Europe on “Justice and Society” adopted by the CCJE at its 6th meeting (strasbourg, 23-25 november 2005), <https://rm.coe.int/1680747698> (сүүлд үзсэн: 2023.09.12).

¹² Мөн тэнд 99 дэх тал.

¹³ Media Influence in Capital Cases, <https://capitalpunishmentincontext.org/issues/media> (сүүлд үзсэн: 2023.09.12).

¹⁴ Aurélie Ouss, Arnaud Philippe, *The impact of the media on court decisions*, <https://www.ipp.eu/wp-content/uploads/2016/01/n22-notesIPP-january2016.pdf>, 2016. 3.

судалгаагаар тогтоогдсон байна.¹⁵ Энэ талаар Хятадын сэтгүүлзүй, хууль зүйн ухааны эрдэмтэн Вэй Юнжэн "...Хэвлэл мэдээллийн байгууллагын бодитой, шударга байх зарчмыг зөрчиж шүүхийн байгууллагад үл үзэгдэх дарамт шахалт үзүүлж хэвлэл мэдээллийн эрх чөлөө нэрийн дор шүүхийн хараат бус байдалд халдаж байна." гэж дурджээ.

Харин *иргэний хэргийн шүүхийн хувьд* хэвлэл мэдээллийн байгууллагын нөлөөлөл нь эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт үзүүлэх нөлөөнөөс өөр байдаг. Учир нь эрүүгийн хэргийн хувьд гэмт этгээдүүдэд олон нийт хатуу чанга ял оногдуулахыг илүүд үздэг¹⁶ бол иргэний хэргийн тухайд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг талыг барьсан мэдээллийг олон нийтэд түгээснээр хохирлын хэмжээнд өөрчлөлт орох магадлалтай гэж үздэг байна.¹⁷

Монгол Улсын тухайд дээрх асуудлуудтай холбоотойгоор 2020 онд Оюуны инноваци ТББ-с "Шүүгчийн хараат бус байдал: Шүүх дэх нөлөөлөл" гэх судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгаагаар нийт 275 шүүгчээс анкетын аргаар судалгаа авч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ шүүгчийн хараат бус байдалд хэрхэн нөлөөлж байгаа талаар дараах үр дүн гарсан байна. Үүнд:

"Сүүлийн 3-н жилийн хугацаанд танд хэргийг эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг хэсэгт тодорхой шийдвэр гаргуулахаар нөлөөлж байсан гэж бодож байна уу?" гэх асуултад нийт судалгаанд оролцогчдын 84 нь санал нийлж байна гэж хариулсан бөгөөд "Энэхүү нөлөөлөл хэнээс ирж байсан бэ?" гэх асуултад дээрх 84 шүүгчийн 22 нь олон нийтийн сүлжээ (сошиал медиа), 17 нь хэвлэл мэдээллийн байгууллага гэж хариулсан байна. Энэ нь хэргийн оролцогч, өмгөөлөгчийн дараа орохоор хамгийн их нөлөөлдөг субъектүүд байна.¹⁸

Үүнээс гадна "Сүүлийн 3 жилийн хугацаанд манай улсад хувь шүүгчийн шийдвэр, үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллага (сонин хэвлэл, телевиз, радио гэх мэт)-ын шууд болон шууд бус үйл ажиллагаа нөлөөлж байсан гэж бодож байна уу?" гэх асуултад нийт судалгаанд оролцогчдын 56.92 хувь нь санал нийлнэ гэж "Сүүлийн 3 жилийн хугацаанд манай улсад хувь шүүгчийн шийдвэр, үйл ажиллагаанд олон нийтийн сүлжээ (facebook, twitter, youtube, website гэх мэт)-нд тулгуурлан явуулсан шууд болон шууд бус үйл ажиллагаа нөлөөлж байсан гэж бодож байна" гэх асуултад нийт судалгаанд оролцогчдын 56.40 хувь нь санал нийлнэ хэмээн хариулсан байна.

¹⁵ *Ibid* 3.

¹⁶ Lim, Claire S. H. "Media Influence on Courts: Evidence from Civil Case Adjudication." *American Law and Economics Review* 17, no. 1 (2015): 88.

¹⁷ *Ibid* 89.

¹⁸ Оюуны инноваци ТББ "Шүүгчийн хараат бус байдал: Шүүх дэх нөлөөлөл" судалгааны ажил (шүүгч нараас авсан анкетын асуулгын үр дүн), <https://legaldata.mn/news/13>, 2020 (Сүүлд үзсэн: 2023.09.11).

Түүнчлэн “Цаашид Монгол Улс дахь шүүгчийн хараат бус байдлыг улам бэхжүүлэхэд нөлөөлнө гэж үзэж буй хүчин зүйлсийг сонгоно уу?” гэх асуулгад нийт судалгаанд оролцогчдын 137 нь олон нийтийн сүлжээ (сошиал медиа)-ээс ирэх дарамт, шахалтыг бууруулах, 119 нь хэвлэл мэдээллийн байгууллагаас ирэх дарамт, шахалтыг бууруулах¹⁹ гэж тус тус хариулсан байна.

“Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” хэлэлцүүлэгт /2016 он/ Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч асан Б.Гүнбилэг “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх, хуулийн байгууллагын талаарх хэлэлцүүлэг, мэдээллийг бүрэн цацахгүй, эсвэл гажуудуулдаг, олон сонин, телевизүүд ирж зураг авсан хэрнээ телевизийн эфирээр цацахгүй байгаа нь олон түмэнд мэдээлэл хүргэх үүргээ хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид гүйцэтгэхгүй байна. Сэтгүүлчдийг ямар нэгэн байдлаар цензурддэг нь эндээс харагдаж байгааг анхааруулья²⁰” гэж илтгэлийнхээ үеэр дурджээ.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Л.Энхбилэг²¹ нь “Улаанбаатар ньус” сайтад өгсөн ярилцлагадаа “Сүүлийн жилүүдэд манай улсад шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдуулж хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс өөрсдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргуулахыг хүсэхдээ иргэд олон нийтэд хэт нэг талын буруу, ташаа мэдээлэл тараах үзэгдэл гарах болсон гэжээ.

Иймд дээрх асуулга болон мэдээллээс үзвэл шүүгчийн хараат бус байдалд хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн сүлжээгээр дамжуулан нөлөөлдөг болох нь харагдаж байна. Дээрх асуудлыг даван туулж шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхтэй холбоотойгоор улс орон бүр өөр өөрсдийн эрх зүйн онцлогт нийцүүлэн зөвлөмж боловсруулах, дүрэм, журам гаргах зэргээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүний нэг жишээ нь 2005 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн (цаашид “ЕШЗЗ”) 6 дугаар хурлаар баталсан Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны 7 дугаар зөвлөмжийн С хэсэгт Шүүхээс хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцааны талаар тусгаж өгсөн байна. Үүнд:

ЕШЗЗ-с шүүгчид болон сэтгүүлчдийг бусад байгууллага, иргэдтэй хэрхэн харилцах талаар мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хэргийн талаар олон нийтэд танилцуулахад анхаарах шаардлагатай асуудлуудыг тусгасан үйл ажиллагааны дүрмийг боловсруулж гаргах нь зүйтэй гэж үздэг байна.²² Тодруулбал, Зарим улсууд шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн

¹⁹ Мөн тэнд.

²⁰ “Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг, <https://www.arslan.mn/social/news/29444.shtml> (Сүүлд үзсэн: 2023.09.11).

²¹ Л.Энхбилэг: Шүүгчид шар хэвлэл, цахим дайралтаас айж хараат бус байдлаа алдсан удаагүй, https://www.judcouncil.mn/site/news_full/12097 (Сүүлд үзсэн: 2023.09.11).

²² Article 39, Opinion no. 7 (2005) of the Consultative Council of European judges (ccje) to the attention of the committee of ministers of the Council of Europe on “Justice and Society” adopted by the CCJE at its 6th meeting (strasbourg, 23-25 november 2005), <https://rm.coe.int/1680747698> (сүүлд үзсэн: 2023.09.12).

хэрэгслээр хэрхэн түгээх, дамжуулах хэлбэрийг нарийвчлан тодорхойлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэргийн оролцогчдын (хохилогч, гэрч, прокурор, шүүгч, г.м) нэр эсхүл зургийг ямар нөхцөлд гаргах зэрэг асуудлуудыг нарийвчлан дүрмэндээ тусгадаг байна.²³

Монгол Улсын тухайд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 80 дугаар тогтоолоор “Шүүгч, ажилтны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, нийтлэлийг бүртгэх, танилцуулах, хариу өгөх журам”, 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 77 дугаар тогтоолоор “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам”, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 343 дугаар тогтоолоор “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээллэх журам”-ыг тус тус баталсан.

Түүнчлэн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2014-2020 оны үйл ажиллагааны тайлан болох “Монгол Улсын шүүхийн тайлан”, Монгол Улсын Дээд шүүх, шүүхийн Тамгын газрын 2014-2020 оны үйл ажиллагааны тайлан, Монголын Шүүгчдийн холбооны 2011-2021 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, төлөвлөгөө²⁴, 2020, 2021 оны тайланг²⁵ судлан үзэхэд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч” сургалт²⁶, Монгол Улсын дээд шүүхээс МҮОНРТ-тэй хамтран “Эрх зүйн хөтөч” теле сэтгүүл²⁷, Хууль, эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшиж буй сэтгүүлчдэд чиглэсэн “Шүүхийг сурвалжлах нь” цуврал сургалтын уралдаан²⁸, Монголын Шүүгчдийн холбооноос “Ярьж буй хууль” подкастыг 2021 оноос олон нийтэд хүргэн ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Монголын шүүгчдийн холбооны зүгээс шүүхийн зорилго, чиг үүрэг, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, таниулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Гэвч, үүнээс өөрөөр шүүхээс хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн ямар хэмжээнд харилцах, шүүхийг олон нийтэд таниулах хүрээнд мэдээллийг тэнцвэртэй өгөх талаар дэлгэрэнгүй тусгасан эрх зүйн баримт бичиг хараахан байхгүй байна.

Харин Европын улс орнуудын тухайд шүүхийг олон нийтэд таниулах хүрээнд мэдээллийг тэнцвэртэй өгөх талаар дээр дурдсан ЕШЗЗ-с 2005 онд батлагдсан “Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай” 7 дугаар зөвлөмжид шүүгчид шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх эсхүл олон нийтэд зориулсан мэдэгдэл гаргах

²³ Ibid

²⁴ Монголын Шүүгчдийн холбооны 2011-2021 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, төлөвлөгөө <http://judge.mn/бидний-тухай/> (Сүүлд үзсэн 2023.09.11).

²⁵ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2020, 2021 оны тайлан, <https://www.judcouncil.mn/site/news/22> (Сүүлд үзсэн 2023.09.11).

²⁶ “Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч-10” сургалт эхэллээ (нийтлэл), https://www.judcouncil.mn/site/news_full/12400 (Сүүлд үзсэн 2023.09.11).

²⁷ Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн тамгын газрын 2015 оны жилийн ажлын тайлан, http://www.supremecourt.mn/files/202110/0_1638160524.pdf (Сүүлд үзсэн 2023.09.11).

²⁸ Мөн тэнд.

зэргээр тайлбар гаргах нь зохимжгүй хэмээн шүүх болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн хоорондын харилцааг дараах үндэслэлээр дээшлүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Үүнд:

1. Эдгээр субъектүүд хэрэгжүүлдэг чиг үүргээ харилцан ойлголцох;
2. Олон нийтэд шүүхийн үйл ажиллагааны мөн чанар, цар хүрээ, хязгаарлалтууд, ээдрээ төвөгтэй байдлыг зөв мэдээлэх;
3. Тодорхой хэргийн хувьд үйл баримтын талаар ташаа мэдээлэл гарахаас сэргийлэх, залруулах.²⁹

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС, ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Монгол Улсын Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, хүлээлгэх хариуцлага

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний үндсэн эрх бөгөөд ардчилсан нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход нь чухал нөлөөтэй бөгөөд энэ нь эрх зүйт төрийн салшгүй хэсэг юм. Ардчиллын суурь зарчим болох үг хэлэх эрхийн хүрээнд мэдээ, мэдээллийг хараат бусаар түгээх эрх нь олон ургалч сэтгүүл зүйн гол тулгуур гэжээ.³⁰ Энэ ч үүднээс сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн тухай онцгойлон авч үзэх шаардлагатай байдаг.

Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй бол сэтгүүлчийн мэргэжлийн зан үйлийн хувийн сахилга бат, менежмент юм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэвлэл мэдээллийн ажилтнууд баримтыг мэдээлэх, олон нийтийн санаа бодлыг чиглүүлэх чухал үүрэг, хариуцлага хүлээдэг. Жишээлбэл, Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо (цаашид “ОУСХ” гэх)-ны 30 дахь удаагийн Конгресс Тунисын нийслэл Түнис хотноо 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж Дэлхийн сэтгүүлчдийн ёс зүйн дүрмийг баталсан.

Гэсэн хэдий ч сэтгүүл зүйн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлууд тулгардаг байна. Улмаар энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, сэтгүүлч алдаа гаргасан эсэхийг тогтоох олон улсад түгээмэл хэрэглэгддэг хамгийн тохиромжтой шийдэл нь мэргэжлийн ёс зүйн зарчмын дагуу хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагаар шийдвэрлүүлэх явдал юм. Жишээ нь: ХБНГУ-д хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болох олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл

²⁹ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл, “Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны 7 дугаар зөвлөмж,” *Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн хараат бус байдал (олон улсын баримт бичиг)* 2019, 97 дохь тал

³⁰ Олон ургалч, чөлөөт хэвлэлийн тухай Европын Парламентын 2018 оны 5-р сарын 3-ны өдрийн тогтоол, (2017/2209(INI)).

ажиллагаатай холбоотой гомдлыг хүлээн авч хэлэлцээд хамтын шийдвэр гаргах зорилго бүхий хэвлэлийн зөвлөл ажилладаг байна.

Харин *Монгол Улсын тухайд* анх 1988 онд Монголын сэтгүүлчдийн холбооны дэргэд “Сэтгүүлчдийн эрх, ёс зүйн зөвлөл”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд энэ зөвлөл тухайн үед мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаж, хариуцлага алдсан сэтгүүлчдийн асуудлыг хэлэлцэж, шийдвэр, зөвлөмж гаргаж байсан нь сэтгүүлчдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх, алдаа гаргахаас урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлж байжээ³¹.

Үүний дараагаар 2004 оны сонгуулийн үеэр *сэтгүүлчдийн ёс зүйтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх Хэвлэлийн цэцийг* Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн дэргэд байгуулжээ. Хэвлэлийн цэцийн дүрмийг Монголын сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Сонины Холбоо, Монголын Чөлөөт Сонинуудын Холбооны хамтарсан бага хурлаар хэлэлцэн баталж³² сонгуулийн үеэр энэхүү түр цэцэд хоёр гомдол ирж, цэц дөрвөн удаа хуралдсан тухай тайланд тусгасан байдаг.

Харин 2011 онд Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн удирдлага, бүрэлдэхүүн шинээр зохион байгуулагдсанаас хойш ёс зүй, эрх зүйн туслалцааг сэтгүүлчдэд үзүүлэхэд чиглэн ажиллажээ. Тус байгууллага нь 2012 онд сэтгүүлчдийн эрх зөрчигдсөн, ёс зүйн талаарх 12 гомдлыг, 2013 онд 10 гаруй гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. Ингэхдээ дийлэнхэд нь шүүхэд өгсөн гомдлыг татуулах, талуудыг эвлэрүүлэх, уучлал гуйх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн хэдий ч сэтгүүлчид ёс зүйн зарчмаа үл хүндэтгэх, зөрчих явдал байсаар байна.

Хэвлэл мэдээллийн зөвлөл

Улмаар хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, сэтгүүлчийн мэргэжлийн хэм хэмжээг сахиулах, ёс зүйг төлөвшүүлэхэд үндсэн чиг үүрэг бүхий Хэвлэл мэдээллийн зөвлөлийг 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулж тухайн жилийнхээ 04 дүгээр сарын 14-нд “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” болон “Гомдол санал хүлээж авах журам” баталж гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэж эхэлсэн байна.

Тус хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь 10 бүлэг 32 зүйлээс бүрдэх бөгөөд 4 дүгээр зүйлд “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.” хэмээн 4.2-д “Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.”³³ гэж тусгасан байна. Энэхүү заалтыг нийтэд ил тод байдлаар 2016 онд 2 удаа, 2017 онд 1 удаа, 2022 онд 1 удаа тус тус зөрчсөн хэмээн Хэвлэл мэдээллийн

³¹ Л.Норовсүрэн, М.Зулькафиль, Ч.Чойсамба “Монголын сэтгүүл зүй-100 жил: Хамгийн хамгийн хамгийн”, 2013, 155 дахь тал.

³² Ж.Батбаатар “Хэвлэлийн зөвлөл ба бидний туршлага” өгүүлэл. Глобинтернэшнл ТББ, Нээлттэй Нийгэм Форум “Хэвлэлийн өөрийн зохицуулалт” /Гарын авлага/, 2009. 45 дахь тал.

³³ Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт.

зөвлөлөөс шийдвэрлэсэн байна.³⁴ Жишээлбэл, peguun.mn фэйсбүүк хуудсаар 2022 оны 05 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд хүнсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллүүдийг шууд дамжуулсан. Тодруулбал, редакц мах, махан бүтээгдэхүүн бэлтгэдэг дотоодын үйлдвэр нэгэн Хятад компанид муудсан, чанаргүй махаа нийлүүлдэг байж болзошгүй талаар мэдээлсэн юм. Хороо энэхүү гомдлыг нягтлан хэлэлцээд редакц тухайн байгууллагыг хүнсний аюулгүй байдалтай холбоотой буюу маш ноцтой асуудалд буруутгаж байгаа хэдий ч мэдээллээ бусад түвшний буюу нэмэлт эх сурвалжуудаас баталгаажуулаагүй, эх сурвалж гэх иргэний үг үнэн болохыг батлах ямар нэг баримт, нотолгоо байхгүй байхад байгууллагын нэр хүндэд халдсан гэж үзээд “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 1.1³⁵, 1.2³⁶, 1.3³⁷, 1.6³⁸, 4.2 дахь заалтуудыг зөрчсөн байна хэмээн шийдвэрлэсэн байна.

Үүнтэй адил зохицуулалтыг *Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7-д* “Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.” хэмээн зааж хэвлэл мэдээллийн байгууллагад үүрэг болгон тусгасан байна. Дээрх заалтыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны дагуу хариуцлага хүлээлгэж болохоор байна.

2.2 Шүүхийн Ерөнхий зөвлөлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйлдэлтэй холбоотойгоор ирүүлсэн нөлөөллийн мэдүүлэг болон түүнийг шийдвэрлэсэн байдал

Дээр дурдсанчлан шүүгчдээс нөлөөллийн мэдүүлэг хөтлөн Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлсэн тохиолдолд Шүүхийн Ерөнхий зөвлөл нь нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлэх, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг тус тус хүлээдэг байна.³⁹

³⁴ Хэвлэл мэдээллийн зөвлөл, Мэдээ, мэдээлэл, <https://www.mediacouncil.mn/as/shiidver/2>, (сүүлд үзсэн: 2023.09.12).

³⁵ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын (2015) 1.1 “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.”

³⁶ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын (2015) 1.2 “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ.”


³⁷ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын (2015) 1.3 “Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, эшлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.”

³⁸ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын (2015) 1.6 “Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана.”

³⁹ Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021) 45 дугаар зүйлийн 45.5 “Ерөнхий зөвлөл энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.”, 45.7 “Ерөнхий зөвлөл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлнэ.”

Уг судалгааны хүрээнд 2020, 2021, 2022 болон 2023 оны эхний хагас жилийн байдлаар шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хөтлөн ирүүлсэн нөлөөллийн мэдүүлгийн тоо болон дээрх нөлөөллийн мэдүүлгүүдэд сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагад хамааралтай нөлөөллийн мэдүүлэг байгаа эсэх талаарх тоон мэдээлэл, нөлөөллийн мэдүүлэг шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй авч үзлээ.⁴⁰ (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Шүүгчийн хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг болон хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй холбоотой нөлөөллийн мэдүүлгийн тоо



Дээрх 8 нөлөөллийн мэдүүлгээс гэмт хэргийн шинжгүй хэмээн хэргийг хааж шийдвэрлэсэн 5, хэрэгсэхгүй болгосон 1, шийдвэрлэсэн 1, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа 1 хэрэг байна. Үүнээс хэргийг нөлөөллийн мэдүүлэгтэй холбоотойгоор шийдвэрлэсэн болон шалгагдаж байгаа нэг хэргийн талаар дэлгэрүүлэн авч үзье:

- 1. Эцэслэн шийдвэрлэсэн:** Ч.М өмгөөлөгч Г.Б, А.Б нар хэргийг эцэслэн шийдвэрлээгүй байхад 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр хэвлэлийн бага хурал зарлан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх “Ч.М-г ⁴¹хуульгүйгээр ялласан” “хэргийг ингэж шийдэх гэж байна”, “шүүх хэргийг ингэж шийдэх хэрэгтэй” гэх зэргээр урьдчилсан тайлбар, дүгнэлт хийж, шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг “дураараа, хонгилын эргүү тэнэг, хуулийг уландаа гишгэсэн” гэх зэргээр доромжилж, шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг олон нийтэд буруу байдлаар тайлбарлан хүргэж, нууцын зэрэглэлтэй хэргийн үйл баримт, хэргийн оролцогчдын нэрийг нийтэд зарлаж шүүгчид нөлөөлөхөөр оролдсон хэмээн үзсэн

⁴⁰ Хэргийн үйл баримтын талаар дэлгэрэнгүйг Хавсралт 1-с үзнэ үү.

⁴¹ Уг судалгаанд холбогдогчийн нэрсийг товчилж оруулсан болно.

бөгөөд дээрх хэргийг Зөрчлийн тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүн тус бүрд нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 1,000,000.00 (нэг сая) төгрөгийн торгох шийтгэлийг оногдуулж шийдвэрлэсэн.

2. **Хэрэг үүсгэн шалгагдаж байгаа:** Хохирогч Б-ийн ээж З нь Сэлэнгэ зар гэх жаран долоон мянган гишүүнтэй фейсбүүк хуудсанд “Хүүхэд зодуулсан үнэнээр шүүдэггүй ээ шүүх хурал нээлттэй хийлгэе гэж хүүхэд эрхээ хангуулах гэсэн чинь шүүгч хүүхэд зодсон даргын эрхийг хангачихсан энэ тэр. Ёоо Монголд үнэн юм гэж нэг ч алга А-ээ больж үз Н-ийн эхнэр А⁴² шүүгч та хохирогч хүүхдийн эрхийг хангах ёстой байтал хүүхэд зодсон даргын эрхийг хангана гэнэ ээ та бидний төлсөн татварын мөнгөөр өндөр цалинждагаа анхаарна уу” гэх мэтээр шүүгчийн нэр хүндэд халдсан, илт худал гүтгэсэн мэдээ, мэдээлэл удаа дараа тараасан хэмээн нөлөөллийн мэдүүлэг ирүүлсэн байна. Дээрх үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 233100055 дугаартай хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Дүгнэн үзвээс судалгааны нэгдүгээр бүлэгт дурдсан 2020 оны Оюуны инноваци ТББ-с хийсэн шүүгчийн хараат бус байдал: шүүх дэх нөлөөллийн судалгаагаар нийт 275 шүүгчээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ шүүгчийн хараат бус байдалд хэрхэн нөлөөлдөг эсэх асуултад 22 нь олон нийтийн сүлжээ (сошиал медиа), 17 нь хэвлэл мэдээллийн байгууллага нөлөөлдөг, “Монгол Улс дахь шүүгчийн хараат бус байдлыг улам бэхжүүлэхэд нөлөөлнө гэж үзэж буй хүчин зүйлсийг сонгоно уу?” гэх асуулгад нийт судалгаанд оролцогчдын 137 нь Олон нийтийн сүлжээ (сошиал медиа)-ээс ирэх дарамт, шахалтыг бууруулах, 119 нь хэвлэл мэдээллийн байгууллагаас ирэх дарамт, шахалтыг бууруулах гэж хариулсан байтал шүүгчдээс Шүүхийн Ерөнхий зөвлөлд маш бага тооны нөлөөллийн мэдүүлгийг ирүүлдэг нь нөлөөлөл гэж юуг ойлгох, энэ талаар хэрэг шийдвэрлэлт хангалттай бус байгааг нь харуулж байна.

Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөц удирдлага, бодлого зохицуулалтын газар, Азийн сан хамтран 2019 онд 132 шүүгчийг хамарсан судалгаагаар шүүгчид нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөггүй шалтгааны талаар шүүгчдийн 31 хувь нь “ажлын ачаалал их, журамд заасан ажиллагааг хийх төвөгтэй” гэсэн хариултыг өгсөн гэсэн мэдээлэл⁴³ гарсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

3.1 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (цаашид “ИБУИНВУ” гэх)-д сэтгүүлчийн ёс зүйн харилцааг зохицуулсан хэд хэдэн эрх зүйн актууд байдаг. Үүний нэг нь Их Британи болон Ирландын Үндэсний сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл (National Union of Journalists) гэх байгууллагаас 1936 онд гаргасан Ёс зүйн дүрэм (Code of

⁴² Уг судалгаанд холбогдогчийн нэрсийг товчилж оруулсан болно.

⁴³ Ж.Өнөрбаяр: Шүүгчийн хараат бус байдал өөрөөс нь ч хамгаалагдах ёстой, <https://court26.kho.gov.mn/news/print:page,1,524--.html> (Сүүлд үзсэн: 2023.09.11).

conduct) юм. 12 заалтаас бүрдэх уг Ёс зүйн дүрэмд сэтгүүлзүйн үндсэн зарчмуудыг тодорхойлсон байх ба тус 12 заалтыг⁴⁴ дурдвал:

Сэтгүүлч нь:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон нийтийн мэдээлэл авах эрхийг ямар ч үед баримталж, хамгаалах.
- Мэдээллийг үнэн зөв, шударгаар түгээхийг эрмэлзэх.
- Их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд алдаагаа залруулахын тулд боломжит бүх арга хэмжээг авах.
- Тухайн бодит нөхцөл байдал болон сэтгүүлч өөрийн итгэл үнэмшлээ хооронд нь ялгаж салгах.
- Нийтийн ашиг сонирхол, нотлох баримттай холбоотой нийтэд ил болоогүй мэдээллээс бусад мэдээллийг шударга, үнэнч, нээлттэй аргаар олж авна.
- Нийтийн ашиг сонирхол хөндөгдөөгүй тохиолдолд хэн нэгний хувийн амьдралтай холбоотой асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх.
- Мэдээллийн эх сурвалжийн нууцлалыг чандлан хадгалж, хамгаалах.
- Заналхийлэл болон бусад аливаа этгээдийн нөлөөллийг эсэргүүцэж, мэдээлэл олон нийтэд ил болохоос өмнө албан үүргээ гүйцэтгэж байхдаа олж авсан мэдээллийг хувийн ашиг сонирхолдоо ашиглахгүй байх.
- Хүний нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, эрх зүйн байдал, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн байдал, бэлгийн чиг баримжаагаар нь үзэн ядах, ялгаварлан гадуурхахад хүргэх нийтлэл гаргахгүй байх.
- Өөрийн ажиллаж буй хэвлэл мэдээллийн байгууллагаас бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлахдаа дуу хоолой, гадаад төрхөө ашиглан сурталчлахгүй
- Насанд хүрээгүй хүнээс ярилцлага болон зургийг авахдаа хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах.
- Зохиогчийн эрхийг зөрчихөөс зайлсхийх.

ИБУИНВУ-д сонин сэтгүүлийн салбарын бие даасан зохицуулагч байгууллага болох Хэвлэлийн Стандартын Бие Даасан Байгууллага (Independent Press Standards Organisation) гэж байдаг ба уг газраас “Редакторын үйл ажиллагааны дүрэм” (Editor’s Code of Practice)⁴⁵ гэх дүрмийг гаргасан байна. 16 заалтаас бүрдэх тус дүрэм нь сонин, сэтгүүл, цахим мэдээ нийтлэгчдэд зориулагдсан⁴⁶ ба 1936 оны Ёс зүйн дүрэмтэй төстэй бүтэц бүхий ерөнхий зохицуулалттай бөгөөд шүүх, шүүгчид нөлөөлөх тухай нарийн зохицуулалт байдаггүй байна.

1. Шүүхийг үл хүндэтгэх тухай хуулийн зохицуулалт

а) Шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэх нөхцөл

⁴⁴ Code of conduct (1936), <https://www.nuj.org.uk/about-us/rules-and-guidance/code-of-conduct.html>, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

⁴⁵ Editor’s Code of Practice (2021), <https://www.ipso.co.uk/editors-code-of-practice/>, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

⁴⁶ Editor’s Code of Practice (2021), <https://www.ipso.co.uk/media/2032/ecop-2021-ipso-version-pdf.pdf>, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

Сэтгүүлч шүүх, шүүгчид нөлөөлж буй асуудлыг нарийвчлан зохицуулсан ганц хууль бол Их Британийн 1981 оны “Шүүхийг үл хүндэтгэх тухай хууль” (Contempt of Court Act) бөгөөд уг хуулийн гол зорилго нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны шударга байдлыг хамгаалах явдал юм.⁴⁷

Юуны өмнө шүүхийг үл хүндэтгэх гэдэг ойлголтыг тайлбарлах шаардлагатай. Шүүхийг үл хүндэтгэх (contempt of court) гэдэг нь хэн нэгэн шүүхийн үйл ажиллагаанд шударга бусаар нөлөөлөх эрсдэлтэй үед үүсдэг асуудал бөгөөд энэ нь хэн нэгнийг шударга шүүхээр шүүлгэхэд саад болж, шүүхийн шийдвэрийн үр дагаварт нөлөөлж болзошгүй⁴⁸ гэж Их Британийн Засгийн газрын албан ёсны цахим хуудсанд тайлбарласан байна. Корнеллын их сургуулийн Хууль зүйн сургууль шүүхийг үл хүндэтгэх гэдгийг шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байхыг хэлэх бөгөөд аливаа этгээд шударга ёсыг хангахад саад учруулах, хөндлөнгөөс оролцох хандлагатай байх нь шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэлд хамаарна⁴⁹ гэж тайлбарлажээ.

Дээрх хуулийн 1 дүгээр зүйлд “хатуу хариуцлагын дүрэм” (the strict liability rule) гэдгийг тайлбарласан ба энэ нь аливаа хүсэл зоригоос үл хамааран шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах нь шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэл гэж тооцогдох хууль дээдлэх зарчмыг хэлнэ⁵⁰ гэж заажээ. Түүнчлэн уг хатуу хариуцлагын дүрмийн үйлчлэл хязгаарлагдах нөхцөлийг дараагийн зүйлд нь тусгасан байна.

2 дугаар зүйл. Хатуу хариуцлагын дүрмийн хамрах хүрээ, хязгаарлалт.

- (1) Хатуу хариуцлагын дүрэм нь зөвхөн хэвлэн нийтлэхтэй хамааралтай бөгөөд тодруулбал “нийтлэл” (publication) гэдэгт илтгэл (speech), бичвэр (writing), [кабелийн хөтөлбөрийн үйлчилгээнд багтсан программ] болон олон нийтэд эсхүл тодорхой хэсэгт хандсан бусад мэдээ, мэдээлэл багтана.
- (2) Хатуу хариуцлагын дүрэм нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шударга ёсны үйл ажиллагаанд ноцтой саад учруулах, эсхүл сөрөг нөлөө үзүүлэх томоохон эрсдэлийг бий болгож буй нийтлэлд хамаарна.
- (3) Хатуу хариуцлагын дүрэм нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа тохиолдолд гарсан нийтлэлд хамаарна.
- (4) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй явагдаж байна гэж тооцох хугацааг тодорхойлоход 1-р хавсралтыг ашиглана.

Дээрхээс үзвэл уг дүрэм нь зөвхөн идэвхтэй явагдаж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударгаар явагдахад ноцтой саад учруулах эсхүл сөрөг нөлөө үзүүлэх томоохон эрсдэлийг бий болгож байгаа нийтлэлд л үйлчлэхээр заасан гэж дүгнэж болохоор байна.

Энд дурдагдсан эрсдэлийг тооцохдоо тухайн нийтлэл нийтлэгдсэн цаг хугацаатай уялдуулж тооцно гэж ойлгож болно. Нийтлэл болон шүүх хурлын хоорондох зай урт байх тусам тухайн нийтлэл ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бага байдаг гэж

⁴⁷Nicola Laver, “Contempt of Court Act 1981”, <https://www.claims.co.uk/knowledge-base/legal-system/contempt-of-court-act>, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

⁴⁸<https://www.gov.uk/contempt-of-court>, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

⁴⁹ Contempt of court, https://www.law.cornell.edu/wex/contempt_of_court, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

⁵⁰ Contempt of Court Act (1981), art.1.

үздэг байна. Нийтлэлээс үүдэлтэй бодит хохирол байхгүй байгаа нь түүнийг шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэхээс хамгаалж чадахгүй ч ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй эсэхийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байж болох юм.⁵¹

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг идэвхтэй явагдаж байгаа гэж үзэхийн тулд энд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн болон дууссан гэж тооцох хугацаа тодорхой байх шаардлагатай. Энэ хугацааг тус хуулийн хавсралтад нарийн зохицуулж өгчээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхэлсэн гэж үзэх тохиолдлуудыг дурдвал баривчлах тушаалгүйгээр баривчлах⁵², баривчлах тушаал гаргах⁵³, шүүх хуралдаанд оруулахаар зарлан дуудах хуудас олгох⁵⁴, яллах дүгнэлт болон ялыг тодорхойлсон бусад бичиг баримтыг өгөх⁵⁵, Шотландаас бусад газарт амаар нэхэмжлэх⁵⁶ зэрэг багтана. Харин цагаатгах эсхүл ял ногдуулах⁵⁷, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоосон бусад шийдвэр, дүгнэлт, захирамж⁵⁸ зэрэг гарснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дууссан гэж үзнэ.

b) Хүлээлгэх хариуцлага

Хариуцлагын асуудлыг Хуулийн 14 болон 15 дугаар зүйлд нарийвчлан зохицуулсныг хуулиас иш татан дор орууллаа.

14 дүгээр зүйл. Англи, Уэльс дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

- (1) *Шүүх аливаа этгээдэд шүүхийг үл хүндэтгэсэн хэргээр хорих ял оногдуулах эрхтэй бөгөөд (энэ заалтаас бусад тохиолдолд) хоригдох хугацаанд ямар нэгэн хязгаарлалт хамаарахгүй тохиолдолд уг хугацаа нь (өмнө нь суллах шийдвэр гаргах шүүхийн бүрэн эрхэд хохирол учруулахгүйгээр) тодорхой байх ёстой ба ямар ч тохиолдолд **дээд шатны шүүхээс оногдуулсан тохиолдолд хоёр жил, доод шатны шүүхээс оногдуулсан тохиолдолд нэг сараас хэтрэхгүй** байна.*
- (2) *Доод шатны шүүх тухайн этгээдийг шүүхийг үл хүндэтгэсэн хэргээр торгох эрхтэй бөгөөд (энэ заалтаас бусад тохиолдолд) торгуулийн хэмжээнд ямар ч хязгаарлалт байхгүй тохиолдолд **торгууль нь £2,500-аас хэтэрч болохгүй**.*

15 дугаар зүйл. Шотланд дахь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

- (1) *Шүүх тухайн этгээдэд шүүхийг үл хүндэтгэсэн хэргээр хорих ял оногдуулвал (өмнө нь суллах шийдвэр гаргах шүүхийн бүрэн эрхэд хохирол учруулахгүйгээр) хугацаа нь тодорхой байх ёстой.*

⁵¹ “Contempt of Court, Reporting Restrictions and Restriction on Public Access to Hearings”, 2022, <https://www.cps.gov.uk/legal-guidance/contempt-court-reporting-restrictions-and-restrictions-public-access-hearings>, (Сүүлд үзсэн: 2023.09.12).

⁵² Contempt of Court Act (1981), Schedules 4(a).

⁵³ *Ibid*, 4(b).

⁵⁴ *Ibid*, 4(c).

⁵⁵ *Ibid*, 4(d).

⁵⁶ *Ibid*, 4(e).

⁵⁷ *Ibid*, 5(a).

⁵⁸ *Ibid*, 5(b).

(2) Шотландын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийг үл хүндэтгэсэн тохиолдолд хорих, торгох хэлбэрээр оногдуулах ялын дээд хэмжээ нь *хоёр жилийн хорих ял эсхүл торгууль, эсхүл хоёуланг нь доорх тохиолдлоос бусад үед ногдуулна:*

- a) яллах дүгнэлт үйлдэх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эсвэл түүнд холбогдуулан үл хүндэтгэсэн хэргийг шериф (sheriff) шийдвэрлэсэн бол тухайн шийтгэл нь *гурван сар баривчлах эсхүл [стандарт шатлалын 4-р түвшний] торгууль, эсхүл аль алинаас нь хэтрэхгүй байх ёстой*; ба
- b) үл хүндэтгэсэн хэргийг дүүргийн шүүх хянан шийдвэрлэсэн тохиолдолд тухайн шийтгэл нь *жаран хоног баривчлах, эсвэл [стандарт шатлалын 4-р түвшний] торгууль, эсхүл аль алинаас нь хэтрэхгүй байх ёстой*.

Дээрх хуулийн зохицуулалтаас дүгнэвэл Их Британийн хувьд шүүхийг үл хүндэтгэсэн гэж тооцогдвол хариуцлагын дээд хэмжээ нь 2 жилийн хорих ял, харин доод хэмжээ нь стандарт шатлалын 4-р түвшний торгууль буюу £2,500 гэж үзэх боломжтой байна.

3.2 Холбооны Бүгд Найрамдах Герман улс

1874 оны Рейхийн хэвлэл мэдээллийн тухай хууль (**Reich Law Gazette**)-аар хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс **зарчмын хувьд** хүлээн зөвшөөрсөн бөгөөд ингэснээр 19-р зууны сүүлчээр хэвлэл мэдээлэл буюу олон нийтийн сүлжээ нь төрөөс аажмаар хараат бус, бие даасан институци болж хувирсан байдаг.⁵⁹

a. Хэвлэл мэдээллийн бодлого ба эрх зүйн орчин (Medienpolitik und Medienrecht)-ыг авч үзвэл:

ХБНГУ болон Европын бусад улс оронд хэвлэл мэдээллийн бодлого ба эрх зүйн орчин нь хоорондоо нягт уялдаа холбоотой байх бөгөөд ялангуяа цахим мэдээллийн хэрэгслийн нөлөө өнөө үед өдөр ирэх тусам нэмэгдэж буйтай холбоотойгоор аливаа асуудалд ямар арга хэмжээ авах тухай Европын улсууд хэвлэл мэдээллийн бодлогодоо боловсруулж, хуульчилж байна.

Хэвлэл мэдээллийн төрөлд дараах зүйлсийг багтааж ойлгоно. Үүнд:

- Бүх төрлийн кино,
- Телевизийн нэвтрүүлэг, радио,
- Бүх төрлийн цахим хэрэгсэл,
- Бүх төрлийн харилцаа холбооны хэрэгсэл,
- Хэвлэл (сонин, сэтгүүл) гэх мэт...⁶⁰

⁵⁹ Reichsgesetzblatt, Reich Law Gazette: 1943

http://ibasecretariat.org/reichsgesetzblatt_ordinance_1943_eng.pdf, (abgerufen am 07.09.2023).

⁶⁰ Bundeszentrale für Politische Bildung: Medienpolitik und Medienrechts: journalismus Medienpolitik, 2016, <https://www.bpb.de/themen/medien-journalismus/medienpolitik/171581/medienpolitik-und-medienrecht/> (abgerufen am 11.09.2023).

Харин дээрх хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглаж олон нийтэд мэдээлэл түгээж буй хэвлэлүүд болоод сэтгүүлчид нь:

- Мэргэжлээрээ дамжуулан нийгэм, олон нийтийн үзэл бодол, хүн хоорондын харилцааг төлөвшүүлэхэд томоохон нөлөө үзүүлэхэд оршдог буюу чухал ач холбогдолтой мэдээллийг үзэгчдэд цаг алдалгүй түгээдэг байх;
- Иргэдийг соён гэгээрүүлэх;
- Аливаа мэдээ, мэдээллийг шударга, бодитой мэдээлэх;
- Тухайн мэдээллийг хэт дөвийлгөх, олон нийтээс хандалт, сайшаал авахын тулд мэдээллийн агуулгыг гажуудуулж, ямарваа нэг шуугиан дэгдээхээс зайлсхийх;
- Хувь хүний эмзэг мэдээлэлд болгоомжтой хандах;
- Өрөөсгөл, ёс бус хэллэг ашиглахгүй байх;
- Соёлын ялгаа, олон талт байдалд мэдрэмжтэй болоод судалгаатай хандах зэрэг үүргийг хүлээхийн зэрэгцээ өөрсдийн хувийн үзэл бодлыг мэргэжлээсээ салгаж, үнэн зөв байдлын хамгийн дээд стандартыг эрэлхийлж байх ёстой ба олон нийт тэднээс ямагт ёс зүйтэй хандахыг шаарддаг байх хэрэгтэй.⁶¹

ХБНГУ-ын тухайд хэвлэн нийтлэгчдийн эрхийг Үндсэн хуульдаа тусгаж өгсөн ба нийтээр дагаж мөрдөх “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” (Pressekodex)-ийг баталж, сэтгүүлчид, хэвлэн нийтлэгчид тэрхүү ёс зүйн дүрмийг өдөр тутамдаа баримтална..

ХБНГУ-ын **Үндсэн хууль (Grundgesetz für die Bundesrepublik Deutschland)**-ийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сэтгүүл зүй, хэвлэн нийтлэгчдийн институцийг хамгаалах зохицуулалтыг тусгаж өгснөөр энэхүү харилцааг Үндсэн хуулиараа хамгаалсан.⁶² Гэсэн хэдий ч энэхүү хамгаалалт нь хэвлэн нийтлэх эрх чөлөөг нийтэд бүрэн олгосон гэх утгыг агуулаагүй юм.

ХБНГУ-ын Үндсэн хуулийг Монгол Улсын Үндсэн хуультай дараах байдлаар харьцуулан авч үзвэл:

“Үндсэн хууль”

№	Үндсэн хууль (ХБНГУ) - 1949 он	Үндсэн хууль (Монгол улс) - 1992 он
1	5.1 “Хүн бүр өөрийн үзэл бодлоо үгээр, бичгээр, дүрсээр чөлөөтэй илэрхийлэх, түгээх болон нээлттэй эх сурвалжаас мэдээлэл авах эрхтэй. Хэвлэлийн эрх чөлөө, өргөн нэвтрүүлэг ба дүрс бичлэгээр мэдээлэл түгээх эрх чөлөөний баталгааг	16.16 “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.” ⁶⁴

⁶¹ Bundeszentrale für Politische Bildung: Medienpolitik und Medienrechts: journalismus Medienpolitik, 2016, <https://www.bpb.de/themen/medien-journalismus/medienpolitik/171581/medienpolitik-und-medienrecht/> (abgerufen am 11.09.2023).

⁶² Fechner, Frank. Medienrecht: Lehrbuch des gesamten Medienrechts unter besonderer Berücksichtigung von Presse, Rundfunk und Multimedia. Vol. 2154. UtB, 2019, S. 238.

⁶⁴ Үндсэн хууль (1992)-ийн 16 дугаар зүйлийн 16.16.

	төр хангана. Аливаа хяналт /цензур/ тогтоохыг хориглоно. ⁶³	
2	104.1 “Гагцхүү хүчин төгөлдөр хуулийг үндэслэн зөвхөн түүгээр тогтоосон арга хэлбэрээр хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж болно...” ⁶⁵ 104.2 “Эрх чөлөөг хязгаарлах нь үндэслэлтэй эсэх, түүний үргэлжлэх хугацааны талаар гагцхүү шүүгч шийднэ...” ⁶⁶	16.14 “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно...” ⁶⁷

Дээрхээс харахад, ХБНГУ-ын хувьд Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасан эрх чөлөөгөөр төр, иргэн хоорондоо хамтын үзэл бодлоо илэрхийлэх олон талт байдлыг хангах ёстой гэсэн үг юм. Харин 104 дүгээр зүйлийн 104.1, 104.2 дахь хэсэгт эрх чөлөөг хязгаарлаж болох, үл болох, хэрэв хязгаарлахаар бол ямар нөхцөлөөр хязгаарлах вэ гэдгийг ерөнхий байдлаар тусгаж өгчээ.

Монгол Улсын тухайд Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 16.14 болон арван зургадугаар зүйлийн 16.16 дахь хэсэгт энэ талаар мөн тодорхой тусгасан байна. Тиймээс энэхүү хоёр улс хэвлэн нийтлэх эрх чөлөөг Үндсэн хуулиараа олгосны зэрэгцээ мөн хязгаарлаж болохоор хуульчилсан бөгөөд Монгол Улс болон ХБНГУ нь Эрүүгийн хуульдаа мөн адил хэнийг ч гэм буруу нь тогтоогдоогүй байхад гэм буруутайд тооцож болохгүйг тус тус тусгасан байдаг.

Түүнчлэн 1973 оны 9-р сард хүчин төгөлдөр болсон “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” (цаашид “Ёс зүйн дүрэм” гэх) ⁶⁸-ээр аливаа мэдээ мэдээлэл, нийтлэлийг нийтлэхдээ юун дээр анхаарах, хувийн нууцлалыг хэрхэн задруулахгүй байх зэрэг хүний нэр төрийг хүндэтгэхээс эхлээд шүүхээр гэм буруу нь тогтоогдоогүй шүүгдэгчийг хамгаалах, цаашлаад асуудал гаргасан телевиз, редакцид арга хэмжээ авах эрх бүхий этгээд, тэдгээрийн эрх, үүргийн талаар нарийн тодорхой зохицуулсан байна. Тухайлбал;

Энэхүү “Ёс зүйн дүрэм” нь ⁶⁹ онцлох заалтуудаас дурдвал;

1. Ёс зүйн дүрмийн 8 дугаар зүйлд сэтгүүлч буюу хэвлэн нийтлэгчид аливаа мэдээллийг түгээхдээ хүний хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах талаар заасан ба 8.1 дэх хэсэгт Гэмт хэргийн талаар олон нийтэд хэрхэн “мэдээлэх” талаар тусгасан байна. Жишээлбэл, *гэмт хэрэг илрүүлэх мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл нь нийтийн ашиг сонирхол байдаг тул хэвлэн нийтлэх эрх нь сэтгүүлчдэд байхаар зохицуулжээ.* Ингэхдээ “Ёс зүйн дүрэм”-ийн 8.2 дахь хэсгийг

⁶³ 5 Absatz 1 Satz GG.

⁶⁵ § 104 Abs. 1 S. GG.

⁶⁶ *Ibid*, § 104 Abs. 2 S. GG.

⁶⁷ Үндсэн хууль (1992)-ийн Арванзургадугаар зүйлийн 16.14.

⁶⁸ Pressekodex (1973).

⁶⁹ Trägerverein des Deutschen Presserats e.V, Geschichte des Pressekodex: 2023, <https://www.presserat.de/geschichte-des-pressekodex.html> (abgerufen am 12.09.2023).

баримтлахаар заасан байна. “Ёс зүйн дүрэм”-ийн 8.2 дахь хэсэгт “*Олон нийтийн хууль ёсны ашиг сонирхол нь тухайн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн хууль ёсны ашиг сонирхлоос давсан тохиолдолд яллагдагч буюу гэмт хэрэгтнийг илрүүлэхийн тулд түүний овог, нэр, гэрэл зураг болон бусад мэдээллийг нь хэвлэлд нийтэлж болох ба ингэхдээ гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, өмнө ял эдэлж байсан эсэх, ямар төрлийн гэмт хэрэг үйлдсэн эсэх (гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинжийг харгалзах), Мөрдөн байцаах хэлтсээс ирүүлсэн гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах хүсэлт байгаа эсэх зэргийг анхаарч үзэх шаардлагатай юм. Хэрэв гэмт хэргийн сэжигтэн буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гэм буруугүйн шинж тэмдэг байгаа бол дээрх заалт үйлчлэхгүй аж. Өөрөөр хэлбэл, тухайн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа сэжигтний гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй тохиолдолд хэнийг ч гэм буруутайд тооцож, овог, нэр, зураг гэх мэт хувийн мэдээллийг нь олон нийтэд тарааж үл болно гэж дүрмээр зохицуулжээ.*

2. Шүүх хуралд оролцогчид буюу тухайлбал, шүүгч А, прокурор Б, өмгөөлөгч В, шинжээч Г-ийг шаардлагатай тохиолдолд олон нийтэд зарлаж болох ч гэрч, талуудын гэр бүлийн гишүүд болон гуравдагч этгээдүүдийн тухайд тэдний овог, нэр, зураг зэрэг *хувийн мэдээллийг нь нийтлэхийг зөвшөөрдөггүй* байна. Мөн *хохирогчдын хувийн мэдээллийг онцгойлон хамгаалах ёстой* ба учир нь тодорхой хэргүүд (Хүчингийн гэмт хэрэг гэх мэт...) -д хохирогчийн хэн болохыг нийтэд мэдэгдэх нь хохирогчдод аюул учруулдаг гэж үздэг. Харин *хохирогч, түүний гэр бүлийн гишүүд болон эрх бүхий бусад хүмүүс зөвшөөрсөн тохиолдолд хохирогчийн овог, нэр, зургийг нийтэлж болохоор тусгажээ.*⁷⁰
3. Түүнчлэн *гэмт хэргийн талаар мэдээлэхдээ 18 хүртэлх насны хүүхдийн хувийн мэдээллийг нийтлэх, тараахыг улс даяараа хориглодог байна.*⁷¹
4. Сураггүй алга болсон хүмүүсийн овог, нэр, гэрэл зургийг зохих байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр нийтэлж болохоор заасан.⁷²
5. *Хүний бие махбодын болон сэтгэцийн өвчин, гэмтэл нь хүний хувийн нууцын нэг хэсэг болдог бөгөөд энэхүү дүрмээр холбогдох хувь хүн, байгууллагын зөвшөөрөлгүйгээр тэдгээрийг мэдээлэх ёсгүй.*⁷³
6. Гэмт хэргийн талаар мэдээлэх 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулсан⁷⁴-даа тухайн гэмт хэргийн яллагдагчийн үндэс угсаа, шашин шүтлэг, харьяаллыг дурдахгүй байх талаар анхааруулсан ба гэхдээ дээр 8 дугаар зүйлд зааснаар бол нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд харьяаллыг дурдаж болохоор заасан. Харин бусад тохиолдолд 12 дугаар зүйлд заасныг баримтлахаар тус тус заажээ.⁷⁵
7. Мөрдөн байцаалт, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон бусад албан ёсны байцаан шийтгэх ажиллагааны талаар мэдээлж болохгүй бөгөөд эдгээр ажиллагаа нь аливаа сөрөг нөлөөллөөс ангид байх ёстой юм. Гэм буруугүйн зарчим хэвлэл, сэтгүүлзүйн салбараас гадна бусад салбаруудад ч хамаатай юм.⁷⁶

⁷⁰ *Ibid*, 8 Abs. 3 S. Pressekodex

⁷¹ *Ibid*, 8 Abs. 4 S.

⁷² *Ibid*, 8 Abs. 5 S.

⁷³ *Ibid*, 8 Abs. 6 S.

⁷⁴ Neue Richtlinie zur Herfunksnennung von STRAFTÄTERN VON (2017): 2023, <https://www.presserat.de/geschichte-des-pressekodex.html> (abgerufen am 12.09.2023).


⁷⁵ 12 Abs. 1 S. Pressekodex

⁷⁶ *Ibid*, 12 Abs. 2 S.

8. Мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, тайлагнаснаар шүүхээр үнэлэгдэх ёстой байтал олон нийт яллаж дүгнэлт хийх гээд байдаг сул талтай юм. *Шүүхээс бусад этгээдүүд урьдчилан дүгнэх ёсгүй гэж үздэг ба тийм ч учраас үүнд хатуу байр суурьтай ханддаг байна. Хэвлэлүүд, сэтгүүлчид аливаа этгээдийг хэргээ хүлээсэн, эсхүл шүүхээр гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон бол гэмт хэрэгтэн гэж цоллож болно. Үндсэн хуультай бүх улсад хэвлэлүүдийн тухайн мэдээллийг мэдээлэх гол зорилго нь "хэвлэл мэдээллийн хэрэгслээр" ял авсан хүмүүст нэмэлт нийгмийн шийтгэл оногдуулах ёсгүйд оршино.* Өөрөөр хэлбэл, хэвлэлүүд, сэтгүүлчид **хардлага, сэрдлэг** болоод **нотлогдсон гэм буруугийн** хооронд тодорхой **ялгаа зааг** байдгийг заавал мэдэх, ойлгох шаардлагатай.⁷⁷
9. Хэвлэлүүд, сэтгүүлчид хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хараахан эцэслэн батлагдаагүй гэмт хэрэг болон гэм буруу нь хараахан тогтоогдоогүй сэжигтний талаар мэдээлсэн тохиолдолд тухайн этгээдийн хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөөгүй, мөн түүнийг цагаатгасан эсхүл эрүүгийн ялын хэмжээг нь мэдэгдэхүйц бууруулсан тохиолдолд заавал олон нийтэд дахин мэдээлэх үүргийг хүлээнэ.⁷⁸
10. Хэвлэл мэдээллийн хууль болоод сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг баримталж буй эсэхийг төрөөс хараат бус, бие даасан байгууллага болох **"Хэвлэл, мэдээллийн Зөвлөл"** (**"Der Deutsche Presserat"** цаашид **"Зөвлөл"** гэх) бүрэн хянадаг ба уг "Зөвлөл" ажиллах журмаа 1973 онд анх баталсан.⁷⁹ Хэрэв аль нэг сэтгүүлч дүрэм зөрчсөн нь тогтоогдвол уг "Зөвлөл" тухайн сэтгүүлчид дотоод журмаараа холбогдох арга хэмжээг авч хариуцлага тооцдог байна.⁸⁰

ХБНГУ-д дээрх "Ёс зүйн дүрэм"-ийг нийтээрээ дагаж мөрдөх ба ялангуяа сэтгүүлчдээс сэтгүүл зүйн салбарын мэргэжлийн "Ёс зүйн зарчим"-ийг өдөр тутамдаа дагаж мөрдөхийг шаарддаг. Иймээс "Ёс зүйн дүрэм", зарчмууд нь "Зөвлөл"-д ирүүлсэн гомдлуудыг үнэлэх, үнэн зөв шийдвэрлэх үндэс суурь нь болж өгдөг байна.

"Зөвлөл"-өөс тус дүрмийг зөрчсөн этгээдүүдэд авах арга хэмжээ, тэдэнд тооцох хариуцлагынх нь механизмын талаар дэлгэрүүлэн авч үзвэл, юун түрүүнд "Зөвлөл" нь дараах хоёр замаар "Ёс зүйн дүрэм" зөрчигсдөд арга хэмжээ авдаг аж. Үүнд:



1. "Сэтгүүл зүйн салбарын мэргэжилтнүүд мэдээ мэдээллийг олон нийтэд бэлтгэж түгээхдээ хувь хүний мэдээллийн нууцыг задруулах буюу хүний хувийн

⁷⁷ Ibid, 13 Abs. 1 S.

⁷⁸ Ibid, 13 Abs. 2 S.

⁷⁹ Түүнээс хойш одоог хүртэл тогтмол шинэчилж, сайжруулсаар байгаа ба хамгийн сүүлд 2021 оны 10 сарын 19-нд шинэчилсэн.

⁸⁰ §16 Abs. 1 S. Pressekodex.

мэдээллийг хамгаалах эрхийг зөрчиж байна” гэж үзэж байгаа хүн бүр тухайн тохиолдлыг шалгуулахаар “Зөвлөл”-д хандан гомдол гаргаж болно. Хувь хүн, холбоо, нам, эвсэл гээд аль нь ч харгалзахгүй уг Зөвлөлд гомдол гаргах эрхтэй (Beschwerdeberechtigung)⁸¹ бөгөөд сонин, сэтгүүл, цахим орчинд нийтлэгдсэн бүх төрлийн сэтгүүлзүйн салбарын талаарх гомдлыг хүлээн авдаг байна.⁸²

Тус “Зөвлөл”-д гомдол гаргахад үнэ төлбөргүй байдаг ба радио, телевиз гэх мэт мэдээллийн хэрэгслээр дамжуулан ямар нэг сурталчилгааны ажил хийдэггүй гэдгээрээ мөн онцлог юм.⁸³

2. “Зөвлөл” нь дотроо гомдол хүлээн авч шийдвэрлэдэг гомдлын “Хороод”-той ба тухайн “Хороо” (Beschwerdeausschüssen)-д гомдлыг хүлээн авч “Зөвлөл”-ийн нэгдсэн хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэдэг нарийн тогтолцоотой аж.⁸⁴ “Хороо” нь гомдол гаргагчдын ирүүлсэн баримт бичиг, нотлох баримт, гэрчүүдийн мэдүүлгийг өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан үнэлж,⁸⁵ “Ёс зүйн дүрэм”-ийг үндэслэн гомдлыг дараах байдлаар шийдвэрлэдэг.⁸⁶

- Үндэслэлгүй гэж үзэх буюу гомдлыг хүлээн авахаас татгалзах,
- Үндэслэлтэй гэж үзэж, тохирсон арга хэмжээг авах (Журмын §12-т заасан мэдэгдлийг гаргана.),
- Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх (шаардлагатай нөхцөлд)

Зөвлөлийн гишүүд, Зөвлөлтэй хамтрагч байгууллагуудын төлөөлөгчид болоод Зөвлөлийн ажилтнууд гомдлын хэлэлцүүлэг, шийдвэрлэх үйл ажиллагааны процедур, баримт бичгийн нууцлалыг дээд зэргээр хадгалах үүргийг хүлээдэг. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргахын өмнө тэд зөвхөн процедурын бодит байдлын талаар олон нийтэд санал бодлоо илэрхийлж болох бөгөөд хэрхэн яаж шийдвэрлэж, арга хэмжээ авахыг олон нийтэд мэдээлдэггүй (Vertraulichkeit).⁸⁷

Хэрэв гомдол гаргагч иргэн, байгууллага Хорооны гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд шийдвэр (Гомдлын Хороо, Редакцийн мэдээлэл хамгаалах гомдлын хороо эсхүл Хэвлэлийн Зөвлөлийн нэгдсэн хуралдаана)-ийг давж заалдаж болдог байна.

b. Хүлээх хариуцлага

Германы Хэвлэлийн зөвлөлийн жилийн төсөв нь 750 мянган евро байдгаас 200 мянган еврог нь төрөөс өгдөг. Ингэхдээ төр хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах үүднээс,

⁸¹ §1 Abs. 1 S. Beschwerdeordnung.

⁸² Гомдлыг www.presserat.de цахим хаягт байрлах гомдлын маягтыг ашиглан цахимаар эсхүл бичгээр гаргаж болохоор “Гомдол гаргах журам”-ын 2.1-д заажээ.

⁸³ **Trägerverein des Deutschen Presserats e.V**, Beschwerdeordnung: 2023, <https://www.presserat.de/geschichte-des-pressekodex.html> (abgerufen am 12.09.2023).

⁸⁴ *Ibid*, §3 Abs. 1, 3 S.

⁸⁵ *Ibid*, §12 Abs. 2 S.

⁸⁶ *Ibid*, §7 Abs. 1 S.

⁸⁷ *Ibid*, §14 Abs.

нөгөө талаас Хэвлэлийн зөвлөл нь шүүх, прокурорын маш олон ажлыг хөнгөвчилдөг гэдэг утгаар ямар нэгэн болзол тулгадаггүй бөгөөд дээр дурдсанчлан Германы сэтгүүлчид 16 зарчим бүхий Ёс зүйн дүрмийг мөрдөж байна.⁸⁸

Хэвлэлийн зөвлөлтэй хэвлэн нийтлэгчдийн 90 гаруй хувь нь Ёс зүйн зарчмаа мөрдөж ажиллана гэсэн гэрээг сайн дурын үндсэн дээр байгуулж баталгаажуулдаг аж. Хэвлэлийн зөвлөлийн шийдвэрийг баримтлахаас татгалзвал энэ нь хэвлэл мэдээллийн байгууллагын өөрийн зохицуулалтын зарчмыг сааруулж, төрийн зүгээс хэвлэл мэдээлэлд нөлөөлөх шалтаг олгохоос гадна мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн өгч байгаа мэдээлэл, түүний чанарт итгэх итгэлийг сулруулдаг гэж үздэг байна. Германы Хэвлэлийн зөвлөлийн Санал гомдлын хороо нь жилд 4 удаа хуралдаж санал, гомдлыг шийдвэрлэдэг аж. Ингэхдээ дараах тохиолдолд холбогдох шатны арга хэмжээг авдаг.

1. **Зөвлөх** /Ноцтой үр дагаваргүй гэж үзсэн мэргэжлийн техникийн алдаанд/
2. **Буруушаах** /Үнэн бодитой бус мэдээ, мэдээлэл түгээсэн, ноцтой алдаанд/
3. **Зэмлэх** /Сануулга авсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл буруугаа хүлээн, өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Хэвлэлийн зөвлөлөөс гаргасан зэмлэлийг нийтэд зарлах үүрэгтэй. Зөвхөн онцгой тохиолдолд, тухайлбал тухайн нийтлэлд нэр нь дурдагдсан хохирогчийг хамгаалах үүднээс Хэвлэлийн зөвлөлийн зэмлэлийг нийтлэхгүй байж болно./

Германы Хэвлэлийн зөвлөл нь ёс зүйн алдаа гаргасан хэвлэл мэдээллийн байгууллагад мөнгөн торгууль оноодоггүй бөгөөд харин ямар шийтгэл оноосноо хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарладаг байна. Энэ нь сэтгүүлчдийн ёс зүйн талаар нийгэмд хэлэлцүүлэг өрнүүлж буйн нэг хэлбэр юм.⁸⁹

ДҮГНЭЛТ, САНАЛ

Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах нь эрх зүйт төрийн зарчимтай салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл, шүүх эрх мэдэл нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гол институц болохын хувьд шүүгчийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхийг оролдсон этгээдэд Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль зэрэг холбогдох хуулиудаар хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан.

Гэтэл сүүлийн жилүүдэд шүүгч болон шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр, хэргийн материалтай холбоотой мэдээллийг “субъектив өнцгөөс тайлбарлан, бодит байдалд нийцээгүй агуулгаар” хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд дамжуулж, нэвтрүүлж байгаа нь олон нийтийг төөрөгдүүлэх, цаашлаад шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд сөрөг нөлөө үзүүлж

⁸⁸ Т.Батзориг, “ХБНГУ-ын Хэвлэлийн өөрийн зохицуулалтын туршлагаас”, <https://www.mediacouncil.mn/a/5>, 2013.

⁸⁹ Мөн тэнд.

байгаа хэдий ч шүүгчдийн ажлын ачаалал их, журамд заасан ажиллагааг хийх төвөгтэй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулагдаж буй ямар төрлийн үйлдэл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд нөлөөлсөн гэж үзэх талаар нарийвчлан тодорхой тусгаагүйгээс шүүгчид хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөггүй, хөтлөх боломжгүйгээс шалтгаалан энэ талын хэрэг шийдвэрлэлт бага байсаар байна.

Судалгааны зүйлийг сонгон судалсан улсуудын хүрээнд авч үзвэл:

ИБУИНВУ-ын хувьд сэтгүүлч шүүх, шүүгчид нөлөөлж буй асуудлыг нарийвчлан зохицуулсан ганц зохицуулалт нь 1981 оны “Шүүхийг үл хүндэтгэх тухай хууль” юм. Шүүхийг үл хүндэтгэх гэдгийг хэн нэгнийг шударга шүүхээр шүүлгэхэд саад болж, шүүхийн шийдвэрт нөлөөлж болзошгүй байдлаар ойлгоно гэж тайлбарласан. Хэвлэл мэдээлэл нь шүүхийн үйл ажиллагаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болох нийтлэл гаргасан тохиолдолд үүссэн асуудлуудыг тус хуульд заасан хатуу хариуцлагын дүрмээр зохицуулахаар хуульчилжээ.

Хариуцлагыг тооцох механизмын хувьд шүүх тухайн хүнийг шүүхийг үл хүндэтгэсэн хэргээр түүнд хорих ял оногдуулах эрхтэй ба дээд шатны шүүхээс оногдуулж байгаа тохиолдолд 2 жил, доод шатны шүүхээс оногдуулж байгаа тохиолдолд 1 сараас хэтрэхгүй, мөн доод шатны шүүх мөнгөн төлбөрийн торгуулийг оноох эрхтэй бөгөөд торгууль нь £2,500-аас хэтэрч болохгүй байна. Шотландын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийг үл хүндэтгэсэн тохиолдолд хорих, торгох хэлбэрээр шийтгэл оноох зэргээр тус тус нарийвчлан зохицуулсан байна.

ХБНГУ-ын хувьд Үндсэн хуульдаа хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулсан байх бөгөөд өнөө үед маш олон төрлийн мэдээллийн хэрэгсэл бий болж хөгжсөн нь тухайн улсын Үндсэн хуулиар баталгаажсан үзэл баримтлал, хэвлэлийн эрх чөлөөний үр дүн нь болж байна. Сэтгүүлчдийн өдөр тутамдаа болон ажил мэргэжилдээ баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулж, шүүх ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хэрхэн түгээх талаар мөн нарийвчлан тусгаж өгчээ.

Сэтгүүлч “Ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн гэж үзэж буй тохиолдолд “Зөвлөл”-д гомдол гаргаж шийдвэрлүүлж болох ба гомдлыг “Зөвлөл” дэх гомдлын “Хороо” хүлээн авч /сэтгүүлчдийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хянаж, хариуцлага тооцож зохих арга хэмжээг авдаг/ “Зөвлөл”-ийн хуралдаанаар шийдвэрлэдэг ба хүлээлгэх хариуцлагын хувьд мөнгөн торгууль оноодоггүй, харин сэтгүүлч ёс зүйн байдлын талаар нийгэмд хэлэлцүүлэг өрнүүлэх үүрэгтэй болдог нь онцлог бүхий зохицуулалт байна.

Харин **Монгол Улсын тухайд** Шүүхийн Ерөнхий зөвлөлд ирүүлсэн шүүгчийн нөлөөллийн мэдүүлгээс харвал сэтгүүлч болон хэргийн оролцогчид нь олон нийтийн сүлжээгээр дамжуулан шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх боломжтой, нөлөөлдөг нь харагдаж байгаа хэдий ч Монгол Улсын эрх зүйн орчинд энэ талаар нарийвчлан

зохицуулаагүйгээс мөн хэвлэл мэдээллийн байгууллагын ямар үйлдлийг хараат бус байдалд нөлөөлсөн гэж үзэх талаар тодорхой тусгаж өгөөгүйгээс шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал хөндөгдөх эрсдэл бүхий нөхцөл бүрдсэн байна. Тиймээс энэхүү судалгааны үр дүнд дараах саналыг дэвшүүлж байна.

- Шүүхийн байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хэргийн талаар олон нийтэд танилцуулахад анхаарах шаардлагатай асуудлуудыг тусгасан үйл ажиллагааны журам, зөвлөмжийг боловсруулж гаргах. Тодруулбал, шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн түгээх, дамжуулах хэлбэрийг нарийвчлан тодорхойлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэргийн оролцогчдын (хохирогч, гэрч, прокурор, шүүгч, г.м) нэр эсхүл зургийг ямар нөхцөлд гаргах гэх мэт.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж буй ямар төрлийн үйлдэл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд нөлөөлсөн гэж үзэх талаар нарийвчлан тодорхой тусгах. Энэ чиглэлийн суурь судалгааг хийж гүйцэтгэх.
- Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдэд шүүхийн шийдвэр, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн үнэн бодитоор, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд нөлөөлөхгүй байдлаар олон нийтэд мэдээлэх талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах. Хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт шүүх эрх мэдлийн талаар хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгах.

НОМ ЗҮЙ

Эрх зүйн эх сурвалж:

1. Зөрчлийн тухай хууль, 2017 оны шинэчилсэн найруулга.
2. Иргэний хууль, 2002 он.
3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021 он.
4. Үндсэн хууль, 1992 он.
5. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /1998 он/.
6. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим.
7. Шүүхийн тухай хууль, 2021 оны шинэчилсэн найруулга.
8. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2021 оны 49 дүгээр тогтоол.
9. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 331 дүгээр тогтоол.
10. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 343 дугаар тогтоол.
11. Шүүхийн Сахилгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоол.
12. Эрүүгийн хууль /2015 он, шинэчилсэн найруулга/.
13. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019).
14. Дэлхийн сэтгүүлчдийн ёс зүйн дүрэм (2019).
15. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим (2015).

16. Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоол.
17. Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 7 дугаар зөвлөмж (2005).
18. Олон ургалч, чөлөөт хэвлэлийн тухай Европын Парламентын 2018 оны 5-р сарын 3-ны өдрийн тогтоол, (2017).
19. Contempt of Court Act (1981).
20. Code of Conduct (1936).
21. Editor's Code of Practice (2021).
22. Монгол Улсын Үндсэн хууль (1992).
23. Монгол улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ (2015).
24. Рейхийн хууль (Reichsgesetzblatt) (1943)
http://ibasecretariat.org/reichsgesetzblatt_ordinance_1943_eng.pdf.
25. ХБНГУ-ын “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” (Pressekodex).
26. ХБНГУ-ын Хэвлэл мэдээллийн Зөвлөлд “Гомдол гаргах журам” (Beschwerdeordnung).

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, 2004.
2. Ч.Өнөрбаяр, “Шүүгчийн хараат бус байх зарчим түүний онолын үндэслэл, шалгуур” Эрх зүйт ёс, 2010.
3. Н.Лүндэндорж “Шүүх эрх мэдэл” 2017.
4. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021.
5. Ж.Батбаатар “Хэвлэлийн зөвлөл ба бидний туршлага” өгүүлэл. Глобинтернэшнл ТББ, Нээлттэй Нийгэм Форум “Хэвлэлийн өөрийн зохицуулалт” /Гарын авлага/, 2009.
6. Л.Норовсүрэн, М.Зулькафиль, Ч.Чойсамба “Монголын сэтгүүл зүй-100 жил: Хамгийн хамгийн хамгийн”, 2013.
7. Т.Батзориг, “ХБНГУ-ын Хэвлэлийн өөрийн зохицуулалтын туршлагаас”, 2013.
8. Оюуны инноваци ТББ “Шүүгчийн хараат бус байдал: Шүүх дэх нөлөөлөл” судалгааны ажил (шүүгч нараас авсан анкетын асуулгын үр дүн), 2020.

Гадаад хэл дээрх эх сурвалж, цахим хуудас:

1. Хууль зүйн болон бусад салбарын мэдээлэл, судалгаа, шүүхийн шийдвэрийн хайлт, <https://legaldata.mn/>
2. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн цахим хуудас, <https://www.judcouncil.mn/>
3. Мэдээний цахим хуудас, <https://www.arslan.mn/social/news/29444.shtml>
4. Media Influence in Capital Cases
<https://capitalpunishmentincontext.org/issues/media>
5. Aurélie Ouss, Arnaud Philippe, The impact of the media on court decisions, 2016.
<https://shs.hal.science/halshs-02522872/>

6. Lim, Claire S. H. "Media Influence on Courts: Evidence from Civil Case Adjudication." *American Law and Economics Review* 17, no. 1 (2015), <https://www.jstor.org/stable/24735731>
7. Хууль зүйн судалгааны цахим сан: <https://legaldata.mn/news/13>
8. Хэвлэл мэдээллийн зөвлөл: <https://www.mediacouncil.mn/as/shiidver/2>
9. Үндэсний сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн цахим хуудас: <https://www.nuj.org.uk/>
10. Хэвлэлийн стандартын бие даасан байгууллагын цахим хуудас: <https://www.ipso.co.uk/>
11. Санхүүгийн зохицуулах газраас удирддаг нэхэмжлэлийн менежментийн компанийн цахим хуудас: <https://www.claims.co.uk/>
12. Их Британийн Засгийн газрын цахим хуудас: <https://www.gov.uk/>
13. Корнеллын их сургуулийн Хууль зүйн сургуулийн цахим хуудас: <https://www.lawschool.cornell.edu/>
14. Их Британийн хууль тогтоомжийн нэгдсэн систем: <https://www.legislation.gov.uk/>
15. Их Британийн CPS –ийн цахим хуудас: <https://www.cps.gov.uk/>
16. Frank. Medienrecht: Lehrbuch des gesamten Medienrechts unter besonderer Berücksichtigung von Presse, Rundfunk und Multimedia. Vol. 2154. UtB, 2023
17. **Trägerverein des Deutschen Presserats e.V**, Beschwerdeordnung: 2023, <https://www.presserat.de/geschichte-des-pressekodex.html> (
18. Bundeszentrale für Politische Bildung: Medienpolitik und Medienrechts: journalismus Medienpolitik, 2016, <https://www.bpb.de/themen/medien-journalismus/medienpolitik/171581/medienpolitik-und-medienrecht/>
19. Neue Richtlinie zur Herkunftsnennung von STRAFTÄTERN VON (2017): 2023, <https://www.presserat.de/geschichte-des-pressekodex.html>
20. <https://www.dfjv.de/ueber-uns/ethik-kodex> Deutscher Fachjournalisten Verband, Ethik kodex.